

САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 4 дүгээр сарын -ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Сангийн сайдын 2019 оны “Журам шинэчлэн батлах тухай” 101 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Татварын мэргэшсэн зөвлөхөд эрх олгох, сунгах шалгалт авах журам”-д дор дурдсан заалтыг нэмсүгэй:

- 1/ “3.12.14 Цахим шалгалтын горимыг баталж, мөрдүүлэх” гэж;
- 2/ “8.5 Нягтлан бодогч мэргэжлээр ажилласан байх гэдэгт нягтлан бодогч, нягтлан бодох бүртгэл эсхүл санхүүгийн тайланг хянах, шалгах эрх бүхий этгээдийн ажил, албан тушаалд ажилласныг хамруулна.” гэж;

2. Журмын “2.4 дэх хэсгийн “...Татварын англи хэл”, гэсний дараа “Мэдээллийн технологи” гэж, “3.12.6 дахь заалтын “...олшруулах” гэсний дараа “ажлыг зохион байгуулах болон шалгалтын материалыг цахим сангаас түүврийн аргаар сонгож, хянах” гэж, “7.2 дахь хэсгийн “...материал” гэсний дараа “/цахим файл/” гэж, “8.1.1 дэх заалтын “...татварын улсын байцаагчийг” гэсний дараа “эсхүл эрх зүйч мэргэжлээр бакалавр буюу түүнээс дээш зэрэг эзэмшсэн нягтлан бодогчийг” гэж тус тус нэмсүгэй.

3. Журмын 2.6, 5.2, 5.6, 6.5, 6.6, 8.1.2, 8.2.1, 8.3 дахь хэсэг, заалт тус бүрийг дор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

1/2.6 дахь хэсэг:

“Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгох, сунгах шалгалт тус бүрийн нийт оноо 100 /нэг зуу/ байх бөгөөд 70 /дал/ ба түүнээс дээш оноо авсан тохиолдолд шалгалтад тэнцсэн гэж үзнэ.”

2/ 5.2 дахь хэсэг:

“Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгох, сунгах сургалтын хөтөлбөрт нийцүүлэн шалгалтыг авна.”

3/ 5.6 дахь хэсэг:

“Нийгэмлэг нь шалгуулагчийн шалгалтын материалыг 3 сарын хугацаанд хадгалсны дараа гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсэг устгаж, баримтжуулна.”

4/ 6.5 дахь хэсэг:

“Эрх олгох шалгалтад анх удаа бүртгүүлж буй шалгуулагч нь дор заасан баримт бичгийг цаасан эсхүл цахим файл хэлбэрээр бүрдүүлнэ.”

5/ 6.6 дахь хэсэг:

“Шалгалтад бүртгүүлэгч нь энэ журмын 6.5-д заасан бичиг баримтыг цахим файл /pdf, grj/ руу тод харагдахуйц, чанарын шаардлага хангасан байдлаар хөрвүүлж оруулна. Хэрэв бичиг баримтыг нотариатаар гэрчлүүлээгүй бол

эх хувь эсхүл төрийн байгууллагын цахим сайт (www.e-mongolia.mn) болон Төрийн үйлчилгээний цахим /ТҮЦ/ машинаас авсан лавлагааг хавсаргана.”

6/ 8.1.2 дахь заалт:

“Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасан мэргэшсэн нягтлан бодогч, эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодогчийн эрхийн гэрчилгээтэй (АССА, СРА, СМІ гэх мэт) нягтлан бодогчийг энэ журмын 2.5.4-т заасан шалгалтад тэнцсэнд тооцох.”

8/ 8.2.1 дахь заалт:

“Татвар, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр дараах үйл ажиллагаа хэрэгжүүлсэн байх. Үүнд:

а. докторын зэрэг хамгаалсан, эсхүл магистр, докторын ажлыг удирдаж, хамгаалуулсан;

б. эрдэм шинжилгээний болон олон улсын хуралд илтгэл, шүүмж хэлэлцүүлсэн, эсхүл удирдсан, шүүгчээр ажилласан.”

9/ 8.3 дахь хэсэг:

“Энэхүү журмын 8.1.1-д заасан нөхцөлийг Татварын албанаас ирүүлсэн албан бичиг, эсхүл нийгмийн даатгалын дэвтэр, ажилласныг нотлох архивын газрын лавлагаа, мөн эрх зүйч мэргэжлээр төгссөн диплом, эсхүл хуульч, өмгөөлөгчийн гэрчилгээг, 8.1.2-д заасан нөхцөлийг Мэргэшсэн нягтлан бодогчийн гэрчилгээг, эсхүл мэргэшсэн зэрэг эзэмшснийг нотлох албан ёсны гэрчилгээ, диплом зэрэг бусад нотлох баримтыг тус тус үндэслэн тооцно.”

4. Журмын 2.7 дахь хэсгийн “..75..” гэснийг “..70..”, “..18..” гэснийг “..36..” гэж, 2.13 дахь заалтын “... 2.12..” гэснийг “... 2.12.3..”, “..хангуулж, дүнгийн нэгтгэлийг..” гэснийг “.. хангасан гишүүдийн дүнг нэгтгэн..” гэж, 3.15.4 дэх заалтын “..72 цагийн дотор..” гэснийг “..ажлын 5 хоногийн дотор..” гэж, 6.9 дэх хэсгийн “..хураамжийн 50 хувийг..” гэснийг “..хураамжийг өөрийн хүсэлтээр дараагийн шалгалтад шилжүүлэх эсхүл 100 хувь..” гэж тус тус өөрчилсүгэй.

5. Журмын 6.11 дэх хэсгийн “..танхимын..” гэснийг тус тус хассугай.

6. Энэ тушаалын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Ч.Чимидсүрэн/-т үүрэг болгосугай.

САЙД

Б.ЖАВХЛАН